



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/15

Мөрөн сум

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2021 оны 67 дугаар тогтоол, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/166 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01/75 тоот албан бичгийн дагуу аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын төрөлжсөн мэргэжлийн эмчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүрэг бүхий хамтарсан комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга: Л.Юмжирдулам (Нийгмийн даатгалын хэлтсийн дарга)

Гишүүдэд:

Ч.Ганбаатар

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Гэрэлтуяа

(Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл
мэндийн төвийн дарга)

Ө. Отгонцэрэн

(Хүмүүн эмнэлгийн захирал)

Нарийн бичгийн дарга:

З.Эрчмаа

(Нийгмийн даатгалын хэлтсийн магадлагч
эмч)

2. Сонгон шалгаруулалтыг “Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмчийг сонгон шалгаруулах журам”-ын дагуу 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрөөс 02 дугаар сарын 18-ны өдрийг хүртэлх хугацаанд үр дүнтэй зохион байгуулж тайлагнаж ажиллахыг Комиссын дарга (Л.Юмжирдулам)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т даалгасугай.

ОРЛОГЧ

М.ХУЯГБААТАР